



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 614

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгч томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн “Концессын гэрээ цуцлах тухай” 148 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагын эрх болон хөрөнгийг “Кью Эс Си” ХХК-аас буцаан шилжүүлэн авах тухай” 123 дугаар тогтоол гарсантай холбогдуулан “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлыг эрх бүхий этгээд томилох хүртэл хугацаанд захирлын үүргийг түр гүйцэтгэх төрийн өмчийн төлөөлөгчөөр Ц.Шинэхүү (ТӨУЗХ-ийн Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын албаны дарга)-г томилсугай.

2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах, компанийн дүрэм, бүтэц болон эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшинг боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн төлөөлөгч Ц.Шинэхүүд даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулан ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ